



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2017 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 5/01

Эрдэнэт

Журам батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, 19 дүгээр зүйлийн 19.1, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

Нэг. "Орхон аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журам"-ыг нэгдүгээр хавсралтын ёсоор, "Тусгай зөвшөөрөл хүссэн аж ахуйн нэгжийн танилцуулга"-ын маягтыг хоёрдугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

Хоёр. Аймгийн Засаг дарга Д.Батлутд ДААЛГАХ нь:

2.1. Журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, дүнг жил бүрийн IY улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулах.

2.2. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлд тусгагдах нийтийн эрх ашиг, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад чиглэсэн нөхцөл, шаардлагыг шинээр батлан гаргаж, түүний дагуу өмнө нь олгогдсон бүх тусгай зөвшөөрлийг хянан үзэж, дээрх нөхцөлүүдийг тусгасан гэрээг байгуулах ажлыг тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллага бүртэй 2017 оны III улиралд багтаан хийж дуусгах.

2.3. Согтууруулах ундаа худалддаг, түүгээр үйлчилдэг цэгүүдэд 2017 оны 5 дугаар сард багтаан аттестатчилал явуулж, илэрсэн зөрчлийг арилгуулах.

Гурав. Зөвшөөрөл олгох, сунгахтай холбоотой хувь хэмжээг тогтоох эрхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд шилжүүлсүгэй.

Дөрөв. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2011 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн Ээлжит XIII хуралдааны 07 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



П.ПҮРЭВЛХАГВА

C:\Togtool \-A4 doc

00100132